БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын гуравдугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021 /160/-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг:Sodnomp@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ............................................**Error! Bookmark not defined.**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....................................................................................5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................................................................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..................................................................6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.........................................................................8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............................................10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ...................................................................10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .................................................................12

3. Аудитын тайлан..............................................................................................................13

3.1. Ерөнхий зүйл.................................................................................................................13

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..............................................13

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ......................................................13

3.4. Материаллаг байдал .....................................................................................................13

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ...........................................................................14

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....................................................15

3.7. Шилэн дансны мэдээлэл...............................................................................................15

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....................................................................................16

3.9. Аудитын илрүүлэлт.......................................................................................................16

Залруулсан алдаа..............................................................................................................16

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..................................16

Аудитын зөвлөмж...............................................................................................................17

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ......................................................................................17

4. Менежментийн захидал...................................................................................................17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ...............................................................19

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021. 02. 22. № 60

танай ____________ -ны № ______________ т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ГУРАВДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ГЭРЭЛТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

006020129

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **42,353,172.00** | **60,306,422.09** |
| **33** | **АВЛАГА** | 300,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 300,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 300,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42,053,172.00 | 60,306,422.09 |
| **351** | **Түүхий эд материал** | 506,260.00 | 1,949,700.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 491,260.00 | 1,949,700.00 |
| 35130 | Эм боох материал | 15,000.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 41,546,912.00 | 58,356,722.09 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 940,400.00 | 686,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,781,170.00 | 46,584,102.09 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 900,000.00 | 1,904,360.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,235,242.00 | 2,283,160.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,690,100.00 | 6,898,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,332,484,468.79** | **4,314,511,216.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,332,484,468.79 | 4,314,511,216.58 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,209,399,135.37 | 4,190,177,883.13 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,186,400,000.00 | 4,186,400,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (145,361,111.00) | (197,691,110.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 96,429,148.00 | 145,544,602.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,370,584.24) | (41,561,933.13) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 100,860,580.00 | 112,558,097.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,623,785.39) | (26,486,749.42) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,565,760.00 | 10,565,760.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (528,288.00) | (2,113,152.00) |
| 39217 | Ном | 1,027,416.00 | 2,962,369.62 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 123,085,333.42 | 124,333,333.45 |
| 39301 | Програм хангамж | 680,000.00 | 2,030,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (294,666.58) | (396,666.55) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,374,837,640.79** | **4,374,817,638.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,923,350.60** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,923,350.60 | - |
| **413** | **Өглөг** | 3,923,350.60 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,214,658.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 2,708,692.60 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,216,817.60 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 491,875.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,370,914,290.19** | **4,374,817,638.67** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,370,914,290.19 | 4,374,817,638.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,248,214,290.19 | 4,252,117,638.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,248,214,290.19 | 4,248,214,290.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 3,903,348.48 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,374,837,640.79** | **4,374,817,638.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **875,422,630.00** | **971,712,766.73** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **17,624,500.00** | **48,674,166.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,491,300.00 | 48,674,166.73 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 5,925,540.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,565,760.00 | 48,674,166.73 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 10,565,760.00 | 48,674,166.73 |
| **122** | **Тусламжийн орлого** | 1,133,200.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 1,133,200.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **857,798,130.00** | **923,038,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 643,164,200.00 | 746,042,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 643,164,200.00 | 746,042,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,266,500.00 | 6,235,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,116,500.00 | 6,235,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 200,299,800.00 | 170,761,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 200,299,800.00 | 170,761,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 67,630.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 67,630.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **894,020,782.32** | **967,809,418.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **894,020,782.32** | **967,809,418.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 881,835,021.06 | 944,188,848.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 485,465,391.00 | 583,251,778.21 |
| 210101 | Үндсэн цалин | 338,071,471.00 | 398,547,659.34 |
| 210102 | Нэмэгдэл | 81,745,630.00 | 101,123,918.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 25,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 65,648,290.00 | 58,580,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,672,157.74 | 78,189,837.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,257,067.74 | 54,714,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,853,772.00 | 5,901,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,883,018.00 | 4,721,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 970,755.00 | 1,180,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,707,545.00 | 11,672,937.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 198,771,800.00 | 168,830,458.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,680,000.00 | 9,156,882.00 |
| 210302 | Түлш, халаалт | 166,913,300.00 | 152,743,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,178,500.00 | 6,929,676.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,397,792.00 | 12,839,418.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,287,200.00 | 2,410,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,485,000.00 | 808,140.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,696,582.00 | 1,713,838.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 79,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 430,900.00 | 1,861,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,366,410.00 | 3,524,840.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,071,700.00 | 2,441,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,542,244.00 | 11,220,271.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 54,000.00 | 193,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,488,244.00 | 11,027,271.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,783,080.00 | 441,309.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,783,080.00 | 441,309.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 330,000.00 | 80,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 330,000.00 | 80,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 469,730.00 | 3,540,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 391,230.00 | 3,216,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 78,500.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 99,402,826.32 | 85,795,776.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,620,900.00 | 951,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,690,500.00 | 2,772,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 92,091,426.32 | 82,071,176.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,185,761.26 | 23,620,569.80 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,185,750.00 | 8,827,115.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,925,750.00 | 7,750,315.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,076,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 11.26 | 14,793,454.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11.26 | 14,793,454.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(18,598,152.32)** | **3,903,348.48** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(18,598,152.32)** | **3,903,348.48** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **857,580,500.00** | **930,263,392.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **7,224,792.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 7,224,792.00 |
| 120009 | Бусад орлого | - | 7,224,792.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **857,580,500.00** | **923,038,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 643,164,200.00 | 746,042,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 643,164,200.00 | 746,042,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,116,500.00 | 6,235,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,116,500.00 | 6,235,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 200,299,800.00 | 170,761,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 200,299,800.00 | 170,761,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **811,275,539.00** | **910,499,342.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **811,275,539.00** | **910,499,342.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **796,733,527.74** | **884,313,659.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 484,038,390.74 | 584,166,436.21 |
| 210101 | Үндсэн цалин | 336,712,100.00 | 399,683,410.34 |
| 210102 | Нэмэгдэл | 81,678,000.00 | 100,902,825.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 25,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 65,648,290.74 | 58,580,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,504,900.00 | 78,189,837.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,903,300.00 | 54,714,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,900,400.00 | 5,901,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,920,300.00 | 4,721,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 980,100.00 | 1,180,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,800,800.00 | 11,672,937.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 198,771,800.00 | 168,830,458.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,680,000.00 | 9,156,882.00 |
| 210302 | Түлш, халаалт | 166,913,300.00 | 152,743,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,178,500.00 | 6,929,676.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,223,532.00 | 19,316,188.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 876,400.00 | 363,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,485,000.00 | 1,812,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,696,582.00 | 1,713,838.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 79,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 430,900.00 | 3,773,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,674,650.00 | 11,574,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,434,200.00 | 18,961,226.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 168,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,214,700.00 | 17,659,226.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,119,500.00 | 1,134,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,528,000.00 | 1,528,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,528,000.00 | 1,528,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 330,000.00 | 80,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 330,000.00 | 80,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 690,930.00 | 4,182,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 612,430.00 | 3,858,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 78,500.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,211,775.00 | 9,059,314.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,701,600.00 | 4,898,464.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,510,175.00 | 4,160,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,542,011.26** | **26,185,682.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,542,000.00 | 11,392,227.60 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,307,000.00 | 10,292,427.60 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,235,000.00 | 1,099,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 11.26 | 14,793,454.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11.26 | 14,793,454.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **46,304,961.00** | **19,764,050.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **46,304,961.00** | **19,764,050.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **46,304,961.00** | **19,764,050.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 46,304,961.00 | 19,764,050.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 46,304,961.00 | 19,764,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(46,304,961.00)** | **(19,764,050.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 122,700,000.00 | - | 4,272,955,612.51 | 4,395,655,612.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **122,700,000.00** | **-** | **4,272,955,612.51** | 4,395,655,612.51 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (24,741,322.32) | (24,741,322.32) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **-** | **4,248,214,290.19** | 4,370,914,290.19 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **-** | **4,248,214,290.19** | 4,370,914,290.19 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **122,700,000.00** | **-** | **4,248,214,290.19** | 4,370,914,290.19 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 3,903,348.48 | 3,903,348.48 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **122,700,000.00** | **-** | **4,252,117,638.67** | 4,374,817,638.67 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 933342000.00 | 909234937.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 933342000.00 | 891737037.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 918857900.00 | 880344809.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 584247700.00 | 584166436.21 |
| 210101 | Үндсэн цалин | 403216100.00 | 399683410.34 |
| 210102 | Нэмэгдэл | 97451400.00 | 100902825.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25000000.00 | 25000000.00 |
| 210104 | Урамшуулал | 58580200.00 | 58580200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78319900.00 | 78189837.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54714000.00 | 54714000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5901400.00 | 5901400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4721200.00 | 4721200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1180300.00 | 1180300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11803000.00 | 11672937.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 185771800.00 | 168830458.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15680000.00 | 9156882.00 |
| 210302 | Түлш, халаалт | 156913300.00 | 152743900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13178500.00 | 6929676.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32391200.00 | 16582338.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 363400.00 | 363400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1812500.00 | 1812500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,714,800.00 | 1,713,838.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 239,200.00 | 79,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,773,000.00 | 3,773,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,488,300.00 | 8,840,300.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 22,270,200.00 | 18,961,226.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 168,000.00 | 168,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,505,800.00 | 17,659,226.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 596,400.00 | 1,134,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,528,000.00 | 1,528,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,528,000.00 | 1,528,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 90,000.00 | 80,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 80,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,533,000.00 | 4,182,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,859,000.00 | 3,858,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,706,100.00 | 7,824,314.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,900,000.00 | 4,898,464.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,806,100.00 | 2,925,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,484,100.00 | 11,392,227.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,484,100.00 | 11,392,227.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,384,100.00 | 10,292,427.60 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 1,099,800.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **17,497,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 17,497,900.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 17,497,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 916,803,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 746,042,200.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 746,042,200.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 170,761,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 170,761,400.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,235,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,968,850.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,968,850.00 | |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,733,850.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,733,850.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,235,000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,235,000.00 | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,266,150.00** | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,266,150.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | 2,266,150.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,235,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,235,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,235,000.00 | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Гэрэлтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 22–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 01 сарын 18-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын 3-р сургууль нь суралцагчдын суралцах идэвхтэй үйлийг дэмжсэн хичээлийг үр дүнтэй зохион байгуулж, суурь чадамж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн зөв дадал, чадварыг төлөвшүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.

- Суурь чадамжийг баттай эзэмшүүлэх.
- Танхимын ба танхимын бус сургалтыг зохион байгуулах бэлтгэл, арга зүйг хөгжүүлэх.
- Сурагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн хөгжүүлэх сургалтыг чанартай зохион байгуулах, үр дүнг тооцох.
- Би монгол хүн хөтөлбөрийг хөгжүүлэх.
- Эрүүл хүүхэд-аюулгүй орчин- эко сургууль хөтөлбөр хэрэгжүүлэх
- Багш, эцэг, эх олон нийтийн хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх гэсэн зорилтын хүрээнд ажиллажээ.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 524660.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10493.2 мянган

төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн зардлын 2 хувь буюу 19356.2 мянган төгрөгөөр тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 300.0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 42053.2 | 60306.4 | 18253.3 |
| Үндсэн хөрөнгө | 4332484.5 | 4314511.2 | -17973.3 |
| **Нийт хөрөнгө** | 4374837.6 | 4374817.6 | -20.0 |
| Өр төлбөр | 3923.4 | 0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4370914.3 | 4374817.6 | 3903.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 43748376 | 4374817.6 | -20.0 |

Авлага дансны оны эхний үлдэгдэл 300.0 мянган төгрөг барагдаж, тайлант онд авлага үүсээгүй үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60306.4 мянган төгрөг болж 18253.3 мянган төгрөгөөр өссөн нь хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой үйл ажиллагаа явуулаагүйгээс тайлант онд худалдан авсан бараа материал үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4314511.2 мянган төгрөг болж 17973.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны байгуулсан элэгдэлтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 19764.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 44333.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн болон, акталсан хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгө тайлант онд программ хангамжийн 1350.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр данс өмнөх оны 3923.4 мянган төгрөгийг барагдуулж тайлант онд өглөг үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4374817.6 мянган төгрөг болж 3903.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 96290.1 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орсон орлого 38108.4, санхүүжилт 102878.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь цалингийн зардал 77993.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 73788.6 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1080661.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1080661.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 147319.5 мянган төгрөгөөр бууруулж 933342.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 933342.0 мянган төгрөгийн төсөв батласнаас 746042.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 187299.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 746042.2, орон нутгийн төсвөөс 170761.4 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 916803.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 902010.1 мянган төгрөгийг зарцуулж 14793.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 902010.1 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь цалингийн зардал 3532.7, байр ашиглалт 16941.3, хангамж 15808.8, норматив зардал 3308.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 5000.0, дээд шатны төсвийн захирагчаас / БУСГ-аас/ 1235.0 мянган орлогыг бүрдүүлжээ. Үүнээс тоног төхөөрөмж 2266.2, бага үнэтэй түргэн 2733.8, багш нарын шагналд 1235.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 700.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, аудитаар өгсөн 8000.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 0.7 | 2 | 0.7 | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 4 | 8 | 4 | 8 | | | |
| Нийт дүн | | | | | | | |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14094.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5378.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 4405.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4310.0мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг хийгдээгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 9783.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5378.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 4405.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Булган сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 2.3, 4.7 дахь заалтыг зөрчин 893.4 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

2. Хорио цээр тогтоосонтой холбоотой байгууллагын үйл ажиллагааг танхимаар явуулахгүй, түр хугацаагаар зогсоосон байх хугацаанд багш ажилчдад хоолны нэмэгдэлд 4485.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" байгууллагын дотоод журмын 10.2.10-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Бараа үйлчилгээний бусад зардлаас 4405.4 мянган төгрөгийг урсгал засварын материал бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгсөн.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4310.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Зориулалт бус зардал гаргах эрсдэл байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/578 тушаалаар сургуулийн захирал Л.Гэрэлтуяад үр дүнгийн урамшуулал 45 хувиар олгох захирамж гарсан боловч тайлант жилд олгоогүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй өмнөх оны урамшуулал олгосон нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.1. *Эрсдэл*: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

*1.2. Өгсөн зөвлөмж:НББ-ийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж өр төлбөрийг бүрэн тусгаж байх.*

1.3. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Асуудлын бүртгэлтэй танилцан алдаа зөрчлийг зөвшөөрсөн.

*2. Дотоод хяналттай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт*: Дотуур байрны хүнсний зардлаас 2548990 мянган төгрөгийг үдийн цайны зардалд гүйлгэн зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

*2.2. Эрсдэл:* Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

*2.3. Өгсөн зөвлөмж*: Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

1.4. *2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлтэй танилцан алдаа зөрчлийг зөвшөөрсөн.

*3.Бараа материалын данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт*: Бараа материалын дансанд 8 ширхэг 1360.0 мянган төгрөгийн ширээ сандал бүртгэлтэй байгаа нь НББОУС-16-д "Үндсэн хөрөнгө гэж дараах шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын

хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах" хөрөнгийг хэлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*3.2. Эрсдэл*: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, элэгдэл тооцогдохгүй байх.

*3.3. Өгсөн зөвлөмж*: Хөрөнгийг данс хооронд шилжүүлэх хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлж үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР П.СОДНОМ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

**20..**

Аудитын нэр:

***.... 20.. оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код:

САГ-20../../СТА-ТШ3

Шалгагдсан байгууллагын нэр:

**.........................**

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| **ДҮН** | | | | | |